



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/068/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан Утас: 88171516, Цахим хаяг: shurkhaikhaniikhishigaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв	11
2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

2026.02.23 № УВА - 2026/008/НА - САА - ТШЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050168

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>701,479,299.68</u>	<u>434,562,490.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	347,752,417.45	39,079,749.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	347,752,417.45	39,079,749.38
3121	Төгрөг	347,752,417.45	39,079,749.38
31211	Төрийн сангийн харилцах	347,752,417.45	39,079,749.38
33	АВЛАГА	2,626,479.46	577,288.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,626,479.46	577,288.47
35	БАРАА МАТЕРИАЛ	351,100,402.77	394,905,453.04
351	Түүхий эд материал	127,167,002.35	198,873,785.35
35110	Тусгай зориулалттай материал	125,685,052.35	197,670,935.35
35130	Эм боох материал	1,481,950.00	1,202,850.00
354	Хангамжийн материал	223,933,400.42	196,031,667.69
35410	Бичиг хэргийн материал	10,779,345.00	11,786,555.00
35420	Аж ахуйн материал	14,264,830.00	18,551,790.02
35440	Түлш, шатах тослох материал	1,460,000.00	00.00
35460	Хүнсний материал	20,531,150.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	176,898,075.42	165,693,322.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,507,592,333.34</u>	<u>20,064,684,517.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,507,592,333.34	20,064,684,517.66
392	Биет хөрөнгө	3,827,003,822.50	19,387,391,451.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,179,289,203.00	19,548,369,244.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,130,205,105.92	-1,261,515,027.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,145,261,794.26	1,220,349,799.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-720,612,590.63	-711,318,646.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	368,637,096.27	650,810,646.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	-254,572,877.01	-262,002,453.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	258,198,006.89	254,200,300.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-157,997,105.75	-190,507,813.44
39217	Ном	139,005,401.39	139,005,401.39
393	Биет бус хөрөнгө	680,588,510.84	677,293,066.52
39301	Програм хангамж	14,128,383.00	14,128,383.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,239,872.16	-8,535,316.48
39303	Бусад биет бус хөрөнгө	671,700,000.00	671,700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,209,071,633.02</u>	<u>20,499,247,008.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>196,967,229.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	196,967,229.40
413	Өглөг	00.00	196,967,229.40
4136	Бусад өглөг	00.00	196,967,229.40
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	196,967,229.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,209,071,633.02</u>	<u>20,302,279,779.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,209,071,633.02	20,302,279,779.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,213,975,804.87	3,213,975,804.87
51101	Өмч: - төрийн	3,213,975,804.87	3,213,975,804.87
512	Хуримтлагдсан үр дүн	721,755,905.35	15,814,964,051.48
51210	Өмнөх үеийн үр дүн	721,755,905.35	721,755,905.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,093,208,146.13

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,273,339,922.80	1,273,339,922.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,209,071,633.02	20,499,247,008.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,278,656,771.30	24,811,842,869.57
11	ТАТВАРЫН ОРЛОГО	117,213,693.50	15,822,306,993.97
110	Орлогын албан татвар	117,213,693.50	15,822,306,993.97
1100	Хувь хүний орлогын албан татвар	117,213,693.50	15,822,306,993.97
110002	Үйл ажиллагааны орлого	117,213,693.50	15,822,306,993.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	861,374,877.80	918,839,775.60
120	Нийтлэг татварын бус орлого	136,730,977.80	206,949,975.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,676,709.00	119,746,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,674,709.00	106,584,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,002,000.00	13,162,200.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	57,054,268.80	87,203,175.60
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	117,213,693.50	15,822,306,993.97
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,643,900.00	711,889,800.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	724,643,900.00	711,889,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,300,068,200.00	8,070,696,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,300,068,200.00	8,070,696,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,300,068,200.00	8,070,696,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,148,736,054.04	9,694,994,846.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,148,736,054.04	9,694,994,846.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,624,248,059.19	9,106,857,820.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,376,446,924.00	6,371,091,495.44
210101	Үндсэн цалин	3,353,644,051.00	3,540,658,929.70
210102	Нэмэгдэл	1,617,941,388.00	2,155,701,634.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	182,025,000.00
210104	Урамшуулал	404,861,485.00	492,705,931.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	669,727,996.33	789,786,728.87
210201	Тэтгэврийн даатгал	456,814,109.17	540,327,108.61
210202	Тэтгэмжийн даатгал	51,692,427.89	63,694,273.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,886,780.30	31,843,218.92
210204	Ажилгүйдлийн даатгал	26,870,496.29	31,725,294.29
210205	Эрүүл мэндийн даатгал	107,464,182.68	122,196,833.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	625,300,160.15	884,170,834.08
210301	Гэрэл, цахилгаан	30,923,293.03	40,014,564.08
210302	Түлш, халаалт	531,370,092.12	770,830,679.00
210303	Цэвэр, бохир ус	63,006,775.00	73,325,591.00
2104	Хангамж, бараа материалын зардал	149,976,639.39	162,128,764.33
210401	Бичиг хэрэг	17,095,237.50	50,189,631.00
210402	Тээвэр, шатахуун	880,500.00	4,414,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,615,647.90	4,908,748.00

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,041,800.00	60,726,979.98
210408	Бараа материал акталсны зардал	88,343,453.99	41,889,025.35
2105	Нормативт зардал	134,066,540.00	185,415,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	942,250.00
210502	Хоол, хүнс	134,066,540.00	184,472,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,660,900.00	23,834,560.00
210604	Урсгал засвар	54,660,900.00	23,834,560.00
2107	Томилолт, зочны зардал	3,326,000.00	721,000.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,326,000.00	721,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,199,242.23	145,857,080.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,820,000.00	17,949,888.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	123,379,242.23	127,907,192.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	485,543,657.09	543,852,337.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,555,175.20	89,728,045.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,687,980.00	30,488,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	365,300,501.89	423,635,732.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	524,487,994.85	588,137,025.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	516,600,275.00	588,132,630.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	348,484,675.00	534,147,230.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168,115,600.00	53,985,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,887,719.85	4,395.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,887,719.85	4,395.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	129,920,717.26	15,116,848,023.45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	23,639,877.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	23,639,877.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-23,639,877.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	129,920,717.26	15,093,208,146.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,104,388,809.00	8,902,332,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	804,320,609.00	831,636,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	79,676,709.00	119,746,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,676,709.00	119,746,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,674,709.00	106,584,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,002,000.00	13,162,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,643,900.00	711,889,800.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	724,643,900.00	711,889,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,300,068,200.00	8,070,696,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,300,068,200.00	8,070,696,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,300,068,200.00	8,070,696,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,772,377,398.15	9,028,944,568.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,772,377,398.15	9,028,944,568.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,261,554,433.30	8,458,227,712.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,376,446,924.00	6,368,526,034.22
210101	Үндсэн цалин	3,353,644,051.00	3,538,093,468.48
210102	Нэмэгдэл	1,617,941,388.00	2,155,701,634.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	182,025,000.00
210104	Урамшуулал	404,861,485.00	492,705,931.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	671,781,544.82	790,207,799.10
210201	Тэтгэврийн даатгал	456,814,109.17	540,748,178.84
210202	Тэтгэмжийн даатгал	53,745,976.38	63,694,273.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,886,780.30	31,843,218.92
210204	Ажилгүйдлийн даатгал	26,870,496.29	31,725,294.29
210205	Эрүүл мэндийн даатгал	107,464,182.68	122,196,833.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	678,756,280.15	700,365,804.68
210301	Гэрэл, цахилгаан	30,401,488.03	40,014,564.08
210302	Түлш, халаалт	585,348,017.12	587,025,649.60
210303	Цэвэр, бохир ус	63,006,775.00	73,325,591.00
2105	Нормативт зардал	141,776,790.00	179,768,770.00
210502	Хоол, хүнс	141,776,790.00	179,768,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,999,900.00	11,519,600.00

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	37,999,900.00	11,519,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,179,240.63	139,270,192.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,810,900.00	5,220,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,368,340.63	134,049,792.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	228,613,753.70	268,569,512.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	173,085,603.70	230,740,221.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,528,150.00	37,829,291.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	510,822,964.85	570,716,855.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	502,935,245.00	570,712,460.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	360,510,125.00	516,532,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	142,425,120.00	54,180,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,887,719.85	4,395.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,887,719.85	4,395.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	332,011,410.85	-126,611,868.07
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	258,594,690.00	182,060,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	258,594,690.00	182,060,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	258,594,690.00	182,060,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	258,594,690.00	182,060,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-258,594,690.00	-182,060,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	73,416,720.85	-308,672,668.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	274,335,696.60	347,752,417.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	347,752,417.45	39,079,749.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,306,439,105.80	601,093,603.61	5,121,508,514.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,213,975,804.87	1,306,439,105.80	601,093,603.61	5,121,508,514.28

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-135,851,095.44	-135,851,095.44
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,273,339,922.80	721,755,905.35	5,209,071,633.02
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,273,339,922.80	721,755,905.35	5,209,071,633.02
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,213,975,804.87	1,273,339,922.80	721,755,905.35	5,209,071,633.02
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,093,208,146.13	15,093,208,146.13
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,273,339,922.80	15,814,964,051.48	20,302,279,779.15

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,648,561,600.0	8,499,115,568.1	149,446,031.9	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,648,561,600.0	8,499,115,568.1	149,446,031.9	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,028,965,500.0	7,928,403,108.1	100,562,391.9	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,443,671,200.0	6,368,526,034.2	75,145,165.8	98.8
210101	Үндсэн цалин	3,800,784,200.0	3,538,093,468.5	262,690,731.5	93.1
210102	Нэмэгдэл	2,224,398,200.0	2,155,701,634.4	68,696,565.6	96.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.0	182,025,000.0	-182,025,000.0	
210104	Урамшуулал	418,488,800.0	492,705,931.3	-74,217,131.3	117.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	805,459,000.0	790,207,799.1	15,251,200.9	98.1
210201	Тэтгэврийн даатгал	547,712,000.0	540,748,178.8	6,963,821.2	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	64,436,700.0	63,694,273.8	742,426.3	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,218,400.0	31,843,218.9	375,181.1	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	32,218,400.0	31,725,294.3	493,105.7	98.5
210205	Эрүүл мэндийн даатгал	128,873,500.0	122,196,833.3	6,676,666.7	94.8
2105	Нормативт зардал	180,760,400.0	179,768,770.0	991,630.0	99.5
210502	Хоол, хүнс	180,760,400.0	179,768,770.0	991,630.0	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,656,700.0	139,270,192.8	1,386,507.3	99.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,224,500.0	5,220,400.0	4,100.0	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	135,432,200.0	134,049,792.8	1,382,407.3	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	458,418,200.0	450,630,312.0	7,787,888.0	98.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	420,586,800.0	412,801,021.0	7,785,779.0	98.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,831,400.0	37,829,291.0	2,109.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	619,596,100.0	570,712,460.0	48,883,640.0	92.1

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	619,596,100.0	570,712,460.0	48,883,640.0	92.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	565,415,700.0	516,532,060.0	48,883,640.0	91.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,180,400.0	54,180,400.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,238,553,300.0	8,190,442,900.0	48,110,400.0	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,114,956,300.0	8,070,696,100.0	44,260,200.0	99.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,114,956,300.0	8,070,696,100.0	44,260,200.0	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	8,114,956,300.0	8,070,696,100.0	44,260,200.0	0.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,597,000.0	119,746,800.0	3,850,200.0	96.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,800,800.0	106,584,600.0	-2,783,800.0	102.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,796,200.0	13,162,200.0	6,634,000.0	66.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	347,752,417.5	-347,752,417.5	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	39,079,749.4	-39,079,749.4	

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
298	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	711,889,800.0	711,885,404.7	4,395.3	100
299	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	711,889,800.0	711,885,404.7	4,395.3	100
300	Бараа, үйлчилгээний зардал	711,889,800.0	711,885,404.7	4,395.3	100
313	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	700,369,800.0	700,365,804.7	3,995.3	100
314	Гэрэл цахилгаан	69,020,500.00	40,014,564.08	29,005,935.92	73.4
315	Түлш, халаалт	523,778,800.00	587,025,649.60	-13,792,574.4	103.4
316	Цэвэр, бохир ус	107,570,500.00	73,325,591.00	34,244,909.00	103.6
330	Эд хогшил худалдан авах	11,520,000.00	11,519,600.00	400	100.0

**Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

334	Урсгал засвар	11,520,000.00	11,519,600.00	400	100.0
883	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	711,889,800.0	711,885,404.7	4,395.3	100.00
889	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	711,889,800.0	711,885,404.7	4,395.3	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 онд Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024, 2025 оны эхний 10-р сарын санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар хяналт шалгалт, дотоод аудит хийж дараах зөрчил, дутагдал илрүүлсэн байна. Үүнд

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, зардлын эдийн засгийн ангилал буруу бүртгэж, цалингийн зардлаас 17,371.1 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.
2. Багш ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо журамд заасны ажлын хэсэг байгуулаагүй, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, хавтгайруулж 528,8332.3 мянган төгрөг олгосон зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн багшаас бусад орон тооны жишиг нормативаас илүү 2024 онд 6 орон тоо, 2025 онд 7 онд орон тоо /сургалтын менежер, нягтлан бодогч, нярав, сэтгэл зүйч, эмч, сантехникч/

баталж, цалин, нэмэгдэл, урамшуулалд 271,765.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд /ажил олгогчоос/ 34,604.8 мянган төгрөг нийт 306,370.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.

4. Сургуулийн захирлын тушаал нь эрх зүйн чадамжгүй акт үндэслэсэн, тэргүү болон бичвэр хэсэг хоорондоо уялдаагүй, утга агуулгын зөрүүтэйгээс гадна найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаатай, бичвэрийн формат, цаасны зай хэмжээний шаардлагыг хангаагүй зэрэг зөрчилтэй байна.
5. Орон тооны жишиг норматив, сургуулийн бүтэц орон тоонд байхгүй албан тушаал бий болгож, хавсран ажилласны нэмэгдэл 1,846.9 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөр барагдуулах акт тогтоосон байна.

Иймд дээрх 4 албан шаардлага, 1 төлбөрийн актыг хэрэгжүүлж ажиллахыг сургуулийн удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,290,175.4 мянган төгрөгөөр буюу 4 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	347,752.4	39,079.7	(308,672.7)
Авлага	2,626.5	577.3	(2,049.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	351,100.4	394,905.5	43,805.1

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	4,507,592.3	20,064,684.5	15,557,092.2
Нийт хөрөнгө	5,209,071.6	20,499,247.0	15,290,175.4
Өр төлбөр	-	196,967.2	196,967.2
Засгийн газрын хувь оролцоо	5,209,071.6	20,302,279.8	15,093,208.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,209,071.6	20,499,247.0	15,290,175.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39,079.7 мянган төгрөг болж, 308,672.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 577.3 мянган төгрөг болж, 2,049.2 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагчидтай холбогдсон авлага 2,049.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 394,905.5 мянган төгрөг болж, 43,805.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 71,985.9 мянга, бичиг хэргийн материал 1,007.2 мянга, аж ахуйн материал 4,286.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, эм боох материал 279.1 мянга, түлш шатах тослох материал 1,460.0 мянга, хүнсний материал 20,531.1 мянга, бусад хангамжийн материал 11,204.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,064,684.5 мянган төгрөг болж, 15,557,092.2 мянган төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж 15,369,080.0 мянга, машин тоног төхөөрөмж 75,088.0 мянга, тавилга эд хогшил 282,173.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, бусад үндсэн хөрөнгө 3,997.7 мянган төгрөгөөр буурч, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 423,635.7 мянган төгрөгийн зардал гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 196,967.2 мянган төгрөг болж, 196,967.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад төлөх өглөг 196,967.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 20,302,279.8 мянган төгрөг болж, 15,093,208.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 10,088,370.1 мянга, орон нутгийн төсвөөс 889,862.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 1,973,413.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 177,972.4 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрийн хүрээнд 40 арга хэмжээнд улсын төсвөөс 8,114,956.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 103,800.8 мянга, туслах ажиллагааны орлогоос 19,796.2 мянга, орон нутгийн төсвөөс 625,232.2 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,070,696.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 106,584.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 13,162.2 мянга, орон нутгийн төсвөөс 711,885.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 8,499,115.6 мянган төгрөг буюу 98.3 хувьтай, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 711,885.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Улсын төсөв/ /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	10,766.9	10,766.0	0.9	100
2	80233	Хүүхэд хамгаалал	14,443.3	14,316.9	126.4	99.1
3	80312	Сургалт семинар	5,930.2	5,926.6	3.6	100.0
4	81605	Эрүүл мэндийг дэмжих	11,350.8	10,682.0	668.8	94.1
5	81801	Үдийн цай хөтөлбөр	565,415.7	516,532.1	48,883.6	91.3
6	81806	Дотуур байрны үйлчилгээ	541,104.0	481,545.3	59,558.7	88.9
7	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	166,076.3	166,076.3	0.0	100
8	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	44,094.0	44,084.4	9.6	100.0
9	81834	Боловсролын стандарт, сургалты	6,559,918.6	6,552,741.4	7,177.2	99.9
10	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	535,288.1	526,813.9	8,474.2	98.4
11	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	118,800.8	97,032.9	21,767.9	81.7
12	81848	Сурах бичгийн түүрээс	5,224.5	5,220.4	4.1	100
13	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,796.2	3,402.2	1,394.0	70.9

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ДҮН	8,583,209.4	8,435,140.4	148,069.0	98.3
--	------------	--------------------	--------------------	------------------	-------------

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	биелэлтийн хувь
	Код	НЭР				
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	711,889.8	711,885.4	4.4	100
			711,889.8	711,885.4	4.4	100

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл, тайлагнал	0.0	0.0	Тайлант онд программ худалдан аваагүй байна.
2	Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф	0.0	182,025.0	Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 тоот тушаалын дагуу нэг хүнд 1 өдрийн хоол 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	44,094.0	44,084.4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	0.0	Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	2,500.0	2,500.0	Аймгийн 2 телевизтэй гэрээ байгуулан бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь тайлант онд дотуур байрны хүүхдийн хоол болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 9,694,994.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 96,949.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 77,559.9 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 112 мэдээллээс хугацаандаа оруулсан 94, хугацаа хоцорч оруулсан 18 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй нийт 6,350.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,350.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-д “Туршилтаар ажиллах ажилтны үндсэн цалинг тухайн ажлын байрны үндсэн цалингаас багагүй байхаар тогтоох бөгөөд түүнд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговрыг энэ хуульд заасны дагуу олгоно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан ур чадварын нэмэгдэл олгох журмыг зөрчин шинээр томилогдсон 6 албан хаагчид нийт 6,350.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг харгалзахгүйгээр олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан ур чадварын нэмэгдэл олгох журмыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шинээр томилогдсон 6 албан хаагчид нийт 6,350.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг	1	6,350.5					1	6,350.5					

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

харгалзахгүйгээр олгосон байна.											
Дүн	1	6,350.5				1	6,350.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Товч	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Дүн											
Нийт дүн											

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР 

/С.БАТСАЙХАН/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр